# ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭНХБОЛДЫН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар

Нэгжийн нэр: Төрийн захиргаа, удирдлагын газар

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 63.1 | 63.1 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. | 15 | 15 |
| 2. | Арга хэмжээ 2. | 15 | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 15 |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 15 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 15 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15 |
| 4. | Манлайлах | 15 |
| 5. | Багаар ажиллах | 15 |
| 6. | Харилцаа | 15 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | 15 |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | 15 |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | 15 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 15 |

## 4. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт) 70 хүртэлх оноо* | 63.1 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ ) 15 хүртэлх оноо* | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ ) 15 хүртэлх оноо* | 15 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | |

| | | |
|---|---|---|
| | *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 93.1 |

***Үнэлгээ өгсөн:***

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга

***Төсвийн шууд захирагч***

(А.Энхманлай)

*......... оны ..... дугаар сарын 20 -ны өдөр*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

Төрийн захиргаа, удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

***Нэгжийн дарга:***

.................................... (Б.Энхболд)

*......... оны 12 дугаар сарын 20 -ны өдөр*

# ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.21.1** | **Улсын хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх** | **Үйл ажиллагаа** | **Хэрэгжилтийн хувь** | **2023 онд хяналт шалгалтад 97 объектыг хамруулж, нийт эрсдэлийн хувь 5% -аар буурсан, хууль сахин мөрдөлтийн хувь 5%-аар өссөн.** | **Газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны хэрэгжилтийг 80%-д хүргэсэн байна.** | | |
| 1.21.1.6 | Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг Улсын байцаагч нартай хамтран хийж, илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br>Шалгалтын дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлж, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай 35-00/12 дугаартай удирдамжийг батлуулсан. Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн судалгааг гаргасан. | |

## ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.19** | **Тусгай зөвшөөрөл болон мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, хүчингүй болгох,** | **Үйл ажиллагаа** | **Системийн хөгжүүлэлт** | **2021 оноос Салбарын тусгай зөвшөөрөл. Мэргэжлийн байгууллын эрх олгох, тэдгээрт хяналт тавих** | **Салбарын тусгай зөвшөөрөл. Мэргэжлийн байгууллын эрх олгох, тэдгээрт хяналт тавих системд хөгжүүлэлт хийж, хяналтыг сайжруулсан байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **хяналт тавих ажлыг зохион байгуулах** | | | **системийг хэрэглээнд нэвтрүүлсэн.** | | | |
| 2.1.15.1 | Салбарын тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт хяналт тавих системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлыг зохион байгуулах | Урсгал зардал | Системийн хөгжүүлэлт | 2022 онд Зөвшөөрлийн тухай хууль батлагдсан. | Зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлэн Салбарын тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт хяналт тавих системд нэмэлт хөгжүүлэлт хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | - 2024 оны 03 дугаар сарын 09-ний өдөр салбарын тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрх олгох, тэдгээрт хяналт тавих системийн хөгжүүлэлт хийх үйлчилгээнд шалгарч, гэрээ байгуулсан "Лидер вишн групп" ХХК-тай уулзалт зохион байгуулсан.<br>- 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн ГЗБГЗЗЕГ-ын даргын АД/2024-09 дугаар ажлын даалгаврын дагуу төлөвлөгөө гарган, системийн нэмэлт хөгжүүлэлт хийх график гарган, систем хөгжүүлэгч компанитай хамтран ажиллаж байна.<br>- Лидер вишн групп 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 24/11 дугаартай албан бичгийн хавсралтаар систем хөгжүүлэлтийн явцын тайлан ирүүлсэн. | |
| 2.1.15.2 | Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хуулийн этгээдийн тоо | 2023 онд Барилга, хот байгуулалтын Сайдын тушаалаар 28 хуулийн этгээдэд шинээр зөвшөөрөл олгож, 59 хуулийн этгээдийн зөвшөөрлийг сунгасан. | Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагааг цахимаар зохион байгуулж, гэрчилгээ, гэрээг хэвлэж албажуулан, хуулийн этгээдэд олгосон байна. | 2024 оны эхний хагас жилийн байдлаар Ерөнхий газрын даргын тушаалаар 46 хуулийн этгээдэд шинээр зөвшөөрөл олгож, 12 хуулийн этгээдийн зөвшөөрлийг сунгаж, гэрээ, гэрчилгээг хэвлэн албажуулан, хуулийн этгээдэд олгосон байна. | |
| 2.1.15.3 | Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллагын эрх олгох тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, хүчингүй болгох ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хуулийн этгээдийн тоо | 2023 онд Барилга, хот байгуулалтын Сайдын тушаалаар 10 хуулийн этгээдэд шинээр эрх олгож, 22 хуулийн этгээдийн эрхийг сунгасан. | Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагааг цахимаар зохион байгуулж, гэрчилгээ, гэрээг хэвлэж албажуулан, хуулийн этгээдэд олгосон байна. | 2024 оны эхний хагас жилий байдлаар Ерөнхий газрын даргын тушаалаар 11 хуулийн этгээдэд шинээр зөвшөөрөл олгож, 3 хуулийн этгээдийн зөвшөөрлийг сунгаж, гэрээ, гэрчилгээг хэвлэн албажуулан, хуулийн этгээдэд олгосон байна. | |



70

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.15.4 | Газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, хүчингүй болгох ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хуулийн этгээдийн тоо | 2023 онд Барилга, хот байгуулалтын Сайдын тушаалаар 2 хуулийн этгээдэд шинээр эрх олгосон. | Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагааг цахимаар зохион байгуулж, гэрчилгээ, гэрээг хэвлэж албажуулан, хуулийн этгээдэд олгосон байна. | 2024 оны эхний хагас жилийн байдлаар Ерөнхий газрын даргын тушаалаар 2 хуулийн этгээдэд шинээр зөвшөөрөл олгож, 1 хуулийн этгээдийн зөвшөөрлийг сунгаж, гэрээ, гэрчилгээг хэвлэн албажуулан, хуулийн этгээдэд олгосон байна. | |
| 2.1.15.6 | Салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийн сан эрхлэх | Үйл ажиллагаа | Шинээр хүсэлт ирүүлсэн хуулийн этгээд болон инженер техникийн ажилтны мэдээлэл | 2023 онд мэргэжлийн байгууллагын эрхтэй 32 хуулийн этгээдийн, Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 87 хуулийн этгээдийн мэдээллийн сан хөтлөв. | 2024 онд хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн мэдээллийн сан эрхэлсэн байна. | 2024 оны эхний хагас жилийн байдлаар 75 хуулийн этгээдийн мэдээллийн сан хөтлөв. | |

## ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| **Д/д** | **Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **Суурь түвшин** | **Зорилтот түвшин** | **Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)** | **Хувь** |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1.1** | **Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Тухай бүр** | - | | | |
| 4.1.1.1 | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухай бүр | Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 160 дугаар тушаалаар "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг шинэчлэн баталсан. | - Хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд Агентлаг, аймаг, нийслэлийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах, батлуулах ажлыг зохион байгуулсан байна.<br>- Аймаг, нийслэлийн зохион байгуулалтын бүтэц, орон | - Монгол Улсын Ерөнхий Сайдын 2024 оны 14 дүгээр захирамжаар батлагдсан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцож, батлуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын албан тушаалын жагсаалт, ангилал, зэрэглэл, жагсаалтыг Агентлагийн даргын 2024 оны Б/26 дугаар тушаалаар батлуулсан. Үүний дагуу ГЗБГЗЗЕГ-ын хавсралтад заасан нэр бүхий албан хаагчдыг 2024 оны Б/27 дугаар тушаалаар ажил, албан тушаалаас чөлөөлж, албан хаагчдыг 2024 оны Б/28 дугаар тушаалаар тус тус томилон хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>- Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлуулахаар ирүүлсэн саналыг хянаж 2024.01.31-ний өдрийн 1/391 тоот албан бичгээр Хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгаж, чиг үүргүүдийг бүрэн хуваарилан давхардал хийдлийг арилгах, нэгж доторх ажлын ачаалал жигд эсэхийг шинжилж, дахин боловсруулж ирүүлэхийг чиглэл болгож, хүргүүлсэн.<br>- 21 аймгийн ГХБХБГ-ын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэхээр санал боловсруулсан. ГХБХБГ-ын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, 21 аймгаас ирүүлсэн саналыг нэгтгэн Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2 аймаг, 1 суманд ажлын зураг авалт хийх ажлыг хэрэгжүүлсэн.<br>- Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж, Монгол Улсын Ерөнхий | |



-/-

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сайдын 2023 оны 49 дүгээр захирамжаар Авлигатай тэмцэх “5Ш” ажиллагааг холбогдох албан тушаалтнуудад хариуцуулсны дагуу салбарын байгууллагуудын хэмжээнд илрүүлсэн зөрчил, тэдгээрийг арилгах талаар авч хэрэгжүүлсэн ажлыг загварын дагуу нэгтгэн албан бичгээр хүргэгдсэн.<br>- Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид зааснаас илүү цалин, урамшуулал, нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгохгүй байхад анхаарч, батлагдсан төсвийн хүрээнд санхүүгийн сахилга батыг мөрдөн, хэрэгжилтийг хангаж ажиллахыг 21 аймгийн ГХБХБГ-т чиглэл болгосон.<br>- Аймаг, нийслэлийн ГЗБА-ны Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнүүдэд тухай бүр зөвлөгөөг өгч хамтран ажиллаж байна.<br>- Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлуулахаар ирүүлсэн саналыг хууль тогтоомжийн хүрээнд судалж үзэн Агентлагийн даргын 2024 оны Б/56 дугаар тушаалаар батлан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг чиглэл болгон хүргүүлсэн.<br>- Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын зохион байгуулалтын бүтцийг судалж үзэн, Завхан аймгийн ГХБХБГ-ын бүтцийг Агентлагийн даргын 2024 оны Б/51, Төв аймгийн ГХБХБГ-ын зохион байгуулалтын бүтцийг Б/48, Говь-Алтай аймгийн ГХБХБГ-ын зохион байгуулалтын бүтцийг Б/49, Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулалтын бүтцийг Б/50, Ховд аймгийн ГХБХБГ-ын зохион байгуулалтын бүтцийг Б/52, Өмнөговь аймгийн ГХБХБГ-ын зохион байгуулалтын бүтцийг Б/53, Орхон аймгийн ГХБХБГ-ын зохион байгуулалтын бүтцийг Б/60 дугаар тушаалаар өөрчлөлт оруулан аймаг тус бүрд тушаалыг албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг чиглэл болгосон.<br>- Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэл, 84 дүгээр тогтоолоор Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй 5 жил (60 сар), түүнээс дээш хугацаагаар ажилласан төрийн захиргааны албан хаагч мөнгөн урамшуулал олгохоор заасан. үүний хүрээнд 21 аймгийн ГХБХБГ-ын дарга, Ерөнхий нягтлан бодогч, Захиргааны албан хаагч нарт сургалт зохион байгуулж, нэгдсэн судалгааг авч хянаж үзэн мөн Агентлагийн даргын 2024 оны 05 дугаар 22-ны өдрийн 1/1313 тоот албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.<br>- 21 аймгийн ГХБХБГ-ын Газар зохион байгуулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, Кадастрын хэлтсийн мэргэжилтнүүдэд Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөл, шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаарх сургалт зөвлөмжийг өгч ажилласан."Аймгийн ГХБХБГ-ын нэгж, албан хаагчдын ажлын ачаалал жигд эсэхийг шинжилж, чиг үүргүүдийг оновчтой хуваарилах зорилгоор Дархан-Уул, Төв аймгийн ГХБХБГ болон Төв | |



74

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн Батсүмбэр суманд ажлын зураг авалт хийх, үр дүнг танилцуулах" үүрэг, чиглэлийн дагуу орон нутагт томилолтоор ажилласан.<br>- Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг орон нутагт хэрэгжүүлэхийг 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 1/1214 тоот албан бичгээр хүргүүлж, 14 албан хаагчийг ажиллуулахаар томилолтын удирдамжийг боловсруулж, Агентлагийн даргын тушаалаар батлуулсан.<br>- Засгийн газрын 2024 оны 83, 84,128 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлж ажиллахыг 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 1/883 тоот албан бичгээр хүргүүлсэн. | |
| 4.1.1.2 | "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-д нийцүүлэн салбарын албан хаагчдын "Албан тушаалын тодорхойлолт" боловсруулах батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Албан тушаалын тодорхойлолтын тоо | 21 аймгийн ГХБХБГ-ын улсын (ахлах) байцаагчийн 5 албан тушаалын тодорхойлолт, НГЗБА-ны 4 албан тушаалын тодорхойлолт, агентлагийн 19 албан тушаалын тодорхойлолтыг шинээр, агентлагийн 29 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулсан. | - Хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд "Албан тушаалын тодорхойлолт"-ыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна.<br>- Хянаж зөвшөөрөгдсөн албан тушаалын тодорхойлолтыг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | ГЗБГЗЗЕГ-ын шинээр батлуулах, чиг үүрэгт өөрчлөлт орж шинэчлэн боловсруулсан албан тушаалын тодорхойлолтын төслийг Газрын судалгаа, шинжилгээ, бодлого төлөвлөлтийн газар, Орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газар, Төрийн захиргаа, удирдлагын газраас нэгдсэн саналыг авч, хянаж нэгтгэн даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулсан.<br>Салбарын хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт, байгууллагын үйл ажиллагааны стратегитай уялдуулан шинэчлэн боловсруулж, даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаас гарсан санал, зөвлөмжийг тусгаж удирдлагад танилцуулахаар үүрэг өгөгдсөний дагуу холбогдох газруудаас саналыг авч нэгтгэсэн, мөн Төрийн албаны зөвлөлийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэсэн.<br>Агентлагийн даргын 2024 оны Б/56 дугаар тушаалаар тус албаны бүтэц, орон тоог шинэчлэн баталсан. Шинэчлэн баталсан бүтцийн дагуу Маргаан таслах болон Нүүлгэн шилжүүлэлтийн тасгийн төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулах ажлыг Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлүүлэхийг 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 1/1240 дугаар албан бичгээр хүргүүлж шийдвэрлүүлсэн.<br>Агентлагийн албан тушаалын тодорхойлолт (34) боловсруулан хянаж, батлуулахад бэлтгэсэн. | |
| 4.1.1.3 | Сул болон түр эзгүй байгаа орон тоог Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сул болон эзгүй орон тоо | 2023 онд 16 сул орон тоог зарлан сонгон шалгаруулж, нөхөх ажлыг зохион байгуулсан. | - Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна.<br>- Тухайн албан тушаалд нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулах, дүгнэлтийг үндэслэн шийдвэрийн төсөл боловсруулан албажуулах ажлыг зохион байгуулсан байна. | - ГЗБГЗЗЕГ-ын чиг үүрэгт өөрчлөлт орсонтой холбогдуулан хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлж байсан тус газрын Хот байгуулалтын хэлтсийн 5 албан хаагчийг Агентлагийн даргын 2024 оны Б/02, 03, 04, 05, 06, 07 дугаар тушаалаар БХБЯ-нд шилжүүлсэн.<br>- ТАЗ-ийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын хүрээнд сул орон тоог нөхөх ажлыг БХБЯ-ны Салбар зөвлөлөөс зохион байгуулж, Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо авч нэр дэвшигдсэн албан хаагчдыг Агентлагийн даргын 2024 оны Б/11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 23, 23, 24 дүгээр тушаалаар томилсон.<br>- "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын | |



75

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд 5 албан хаагчийг шилжүүлэн томилсон.<br>- Сул болон эзгүй орон тоог нөхөх зорилгоор 4 албан тушаалыг түр орлон гүйцэтгүүлэх шийдвэр батлагдсан.<br>- Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар сул болон эзгүй орон тоонд нэр дэвшигдсэн 15 иргэний асуудлаар албан бичиг хүргүүлж, тухайн албан тушаалд 15 албан хаагчийг томилон ажиллуулсан.<br>- Төрийн үйлчилгээний 3 албан хаагчийг томилж, 2 албан хаагчийг чөлөөлсөн.<br>- 9 иргэнтэй гэрээ байгуулж, 2 иргэний гэрээг цуцалсан.<br>- Хүний нөөцийн чиглэлээр нийт 68 тушаалын төсөл боловсруулж, баталгаажуулан хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | |
| 4.1.1.4 | "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо" цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчилж, бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээ, судалгааг холбогдох газарт хугацаанд нь тайлагнах | | 1144 албан хаагчийн мэдээлэл | 21 аймгийн "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд оруулсан мэдээлэлд хяналт тавин ажилласан. | - "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо" цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчилсэн байна.<br>- Хүний нөөцийн чиглэлээрх салбарын албан хаагчдын бүх төрлийн нэгдсэн судалгаа, мэдээллийг цуглуулж, нэгтгэн цаг хугацаанд нь боловсруулж, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажилласан байна. | - ГЗБГЗЗЕГ-ын албан хаагчдын ажилласан жилийн дэлгэрэнгүй судалгааг Төрийн үйлчилгээний цахим системээс нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх мэдээллийг авч бэлтгэсэн.<br>- Тус газрын нийт албан хаагчдын 2024 оны цалингийн санг 2024.02.08-ны өдрийн Б/34 дүгээр тушаалаар шинэчлэн баталж, цалин хөлсний өөрчлөлт 93, нэмэгдэл өөрчлөлт 93, бусад өөрчлөлт 93 удаа оруулсан.<br>- Шинээр томилогдсон, дотоод хөдөлгөөн орсон 18 албан хаагчийн мэдээллийг системд бүртгэж, чөлөөлөгдсөн, шилжин ажилласан, 5 албан хаагчийг системээс хассан.<br>- Албан хаагчдын цаг ашиглалтад хяналт тавьж, цагийн бүртгэлийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сард 2 удаа гарган СЭЗХ-т хүргүүлж, ажилласан.<br>- 21 аймгийн "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд оруулсан мэдээлэлд хяналт тавин ажилласан.<br>- Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн цалин нэмэгдсэнтэй холбогдуулан албан хаагчдын цалинг Агентлагийн даргын тушаалаар шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>- Дээрх тушаалын дагуу ХНУМТ цахим системд 90 албан хаагчийн цалинг шинэчлэн оруулсан. | |
| 4.1.1.5 | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөсөн арга хэмжээний тоо | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр" 2021-2025-ыг баталсан. | - "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж, биелэлтийг нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2024 оны төлөвлөгөөний төслийг даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн гарсан санал, зөвлөмжийн дагуу дахин боловсруулалт хийж Агентлагийн даргын 2024 оны А/86 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлуулсан.<br>Төлөвлөгөөг 6 үндсэн зорилтын хүрээнд 26 арга хэмжээг төлөвлөсөн.<br>Нэг: "Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, ур чадвар, санал санаачилгыг харгалзан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд"<br>Хэрэгжүүлэх арга хэмжээ нийт-3<br>Хоёр: "Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж тусламж, тэтгэмж, дэмжлэг, нөхөн олговор олгох зорилтын хүрээнд"<br>Хэрэгжүүлэх арга хэмжээ нийт-11<br>Гурав: "Салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог орчин | |



71

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулах зорилтын хүрээнд"<br>Хэрэгжүүлэх арга хэмжээ нийт-2<br>Дөрөв: "Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд"<br>Хэрэгжүүлэх арга хэмжээ нийт-4<br>Тав: "Албан хаагчдын сонирхол, хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагад нийцүүлж чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эвсэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилтын хүрээнд"<br>Хэрэгжүүлэх арга хэмжээ нийт-2<br>Зургаа: "Албан хаагчийн гэр бүлийг дэмжих зорилтын хүрээнд"<br>Хэрэгжүүлэх арга хэмжээ нийт-4<br>Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч хадагтай Б.Оюунгэрэл "Хамгийн дулаахан газар" сэдэвт илтгэлийг "Эмэгтэйчүүдийн зөвлөл" зохион байгуулж нийт албан хаагчдыг идэвхтэй хамрагдуулсан.<br>Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан "Миний аав, ээжийн ажил бидний нүдээр" сэдэвт хүүхдийн гар зургийн уралдаан зарлаж, албан хаагчдын хүүхдүүдийг хүлээн авах арга хэмжээ зохион байгуулсан.<br>Дээрх төлөвлөгөөг ил тод, нээлттэй байдлаар байгууллагын веб болон ABLE системийн олон нийт цэст байршуулсан мөн 21 аймгийн ГХБХБГ-т илгээсэн. | |
| 4.1.1.6 | Байгууллагын ахмад настныг бүртгэлд авах, тэдэнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх арга | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Байгууллагын ахмад настны бүртгэлд 65 ахмад бүртгэлтэй бөгөөд 2 удаа гарын бэлэг | - Байгууллагын ахмад настныг бүртгэлд авах, тэдэнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх арга хэмжээг 2024 оны 2 | - Сар шинийн баярын өдрийг тохиолдуулан тус салбарт ажиллаж байсан 60 ахмад настанд (гурван сая гурван зуун мянган) төгрөгийн хөнгөлөлт, тусламж үзүүлсэн. | |



79

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээг зохион байгуулах | | | гардуулах ажлыг зохион байгуулсан. | болон 10 дугаар сард зохион байгуулсан байна.<br>- Шагналд тодорхойлох, тусламж, дэмжлэг үзүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлүүлсэн байна. | - Бүртгэл судалгааг шинэчлэн гаргасан.<br>- Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд салбарын хүмүүсээ шагнуулахаар холбогдох материалыг хүлээн авч нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлсэн. | |
| 4.1.1.8 | Албан хаагчийн хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу шинэчлэн бүрдүүлэх | Үйл ажиллагаа | Албан хаагчийн тоо | Тус газрын 93 албан хаагчийн хувийн хэргийг шинэчилсэн. | Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу шинэчлэн бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлсэн байна.<br>Аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны үйл ажиллагаанд хэрэгжүүлэх зөвлөмжийг өгсөн байна. | - Ажлаас чөлөөлөгдсөн, шилжин ажилласан 4 албан хаагчийн хувийн хэрэг материалыг хүлээлгэн өгч, нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийн, тойрох хуудас зуруулж ажлыг хүлээлцсэн.<br>- Шинээр томилогдсон албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн, сургалтад хамрагдсан мэдээлэл, үнэлгээний дүн бусад өөрчлөлт, мэдээлэл зэргийг хийж, тухай бүр баяжилтыг хийж байна. | |
| 4.1.1.9 | Салбарын албан хаагчдын шагналын асуудлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Шагнагдсан албан хаагчийн тоо | Салбарын хэмжээнд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-оор 1, "Алтангадас одон"-оор 1, "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар 12 албан хаагч, Газрын даргын "Жуух бичиг"-ээр салбарын 103 албан хаагч шагнагдсан. | Агентлаг, 21 аймгийн ГХБХБГ, Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын ажлын үр дүнг үндэслэн төрийн дээд шагнал, яам, агентлагийн шагнал, салбарын болоод бусад байгууллагын шагналд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | - Агентлагийн "Жуух бичиг"-ээр 38 албан хаагчийг шагнуулах ажлыг зохион байгуулсан.<br>- Агентлаг болон 21 аймгийн ГХБХБГ-ын албан хаагчид, салбарын ахмад настан, мэргэжилийн байгууллагын албан хаагчдыг Төрийн дээд одон медалиар шагнуулахаар ЗГХЭГ-т агентлагийн 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 1/1254 тоот албан бичгээр 165 хүний материалыг хянаж, дэлгэрэнгүй судалгааг гарган хүргүүлсэн.<br>- Газрын харилцааны ажилтны өдрийг тохиолдуулан мэргэжлийн байгууллагын 10 иргэнийг Агентлагийн даргын "Жуух бичиг", мөнгөн шагналаар шагнуулах ажлыг зохион байгуулсан. | |



80

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг олгох асуудлыг судалж, салбарын шагнал олгох журмын төсөл боловсруулж, бүх нэгжийн дарга нараас санал авч удирдлагад танилцуулсан. | |
| 4.1.1.10 | Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулж, хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, биелэлтийг улирал тутам Төрийн албаны зөвлөлд танилцуулсан байна. | Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийн 5.7 дахь заалтын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дэргэдэх "Салбар зөвлөл" ажиллуулах асуудлаар 2024.01.15-ны өдрийн 1/125 тоот, 2024.04.30-ны өдрийн 1/1095 тоот албан бичгүүдээр хүсэлтээ уламжилсан. Мөн салбар зөвлөл ажиллуулах тогтоол, тушаалын төсөл, байгууллагын танилцуулга, бүрэлдэхүүнд орох 9 албан хаагчийн танилцуулга, холбогдох мэдээллийг тус бүрээр бэлтгэн илгээсэн. | |
| 4.1.1.11 | Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо | Газрын даргын 2019 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А/195 тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн баталсан. | - Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажилласан байна.<br>- Албан хаагчдын 2024 оны ээлжийн амралтын хуваарийг гарган Газрын даргаар батлуулсан байна. | "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын хүрээнд дараах ажлыг зохион байгуулан ажилласан.<br>- 2024 оны ээлжийн амралтын хуваарийг Агентлагийн даргын 2024 оны Б/42 дугаар тушаалаар баталсан. Батлагдсан хуваарийн дагуу 93 албан хаагчид ээлжийн амралтын мэдэгдэл олгож, ээлжийн амралтыг эдлүүлэхээр хяналт тавин ажиллаж байна<br>- Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд санал өгч Хуулийн хэлтэстэй хамтран ажилласан. Хөдөлмөрийн дотоод журмын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>- Албан хаагчдыг албан томилолтоор ажиллуулах журмын төслийг шинэчлэн боловсруулж, ажлын хэсэгт танилцуулан, бүх нэгжийн дарга нараас санал авч Агентлагийн даргын 2024 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн Б/188 тушаалаар батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг нийт албан хаагчдад Able системээр түгээсэн. | |
| 4.1.1.12 | Салбарын сургалт, ажиллах хүчний бүх төрлийн судалгаа хийх | Үйл ажиллагаа | Судалгааны тоо | - | Салбарын сургалт, ажиллах хүчний бүх төрлийн судалгаа хийж, нэгжүүдийг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан байна. | Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 49 дүгээр захирамжаар Авлигатай тэмцэх "5Ш" ажиллагааг холбогдох албан тушаалтнуудад хариуцуулсны дагуу салбарын байгууллагуудын хэмжээнд илрүүлсэн зөрчил, тэдгээрийг арилгах талаар авч хэрэгжүүлсэн ажлыг 21 аймаг, нийслэлийн ГЗБА-аас загварын дагуу авч, нэгтгэн Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.<br>Удирдлагын академийн 2024 оны сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдаж буй сургалтад холбогдох албан хаагчдыг хамруулан, хяналт тавин ажиллаж байна.<br>ажлыг зохион байгуулж байна. Салбарын мэргэжилтэй ажилтны, давтан сургах, мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг олгох дүрмийн төслийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд төслийг боловсруулж удирдлагад танилцуулсан бөгөөд бүх нэгжийн дарга нараас санал авч, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албажуулах ажлыг зохион байгуулж байна. | |
| 4.1.1.13 | Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, дотоод ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | - | Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, дотоод ажил, хурал, уулзалт, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | Агентлагийн даргын 2024 оны А/110 дугаар тушаалаар байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт тус газрын 7 албан хаагч оролцож, тус нэгжээс боловсруулсан 6 баримт бичгийг шинэчлэн боловсруулж батлуулсан бөгөөд 5 журмыг даргын тушаалаар батлуулахад бэлэн болсон байна.<br>Нэгжийн хэмжээнд байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журам, заавар, тушаал, шийдвэрийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж дараах ажлуудыг зохион байгуулав.Үүнд:<br>- Архивын ерөнхий газартай хамтран байгууллагын албан хаагчдад "Албан хэрэг хөтлөлт"-ийн аргазүйн сургалт;<br>- ХААИС-тай хамтран салбарын ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгчдийн төлөөллийг хамруулан "Сургалтын хөтөлбөрийн хөгжүүлэлтэд оролцогч талуудын оролцоо" сэдэвт хэлэлцүүлэг;<br>- АТГ-тай хамтран аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудад зориулсан "Олон нийтийн итгэлийг хүлээсэн ангид нийтийн албыг бэхжүүлнэ" сэдэвт сургалт;<br>- Байгууллагын 1 дүгээр улирлын тайлангийн хурал;<br>- Нэгжийн хурлыг 7 удаа тус тус зохион байгуулав.<br>Мөн байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээнд нэгжийн албан хаагчид идэвхтэй хамрагдаж байна | |



82

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1.6** | **Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, дүгнэх ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Батлагдсан журам, аргачлал, загварыг мөрдсөн байдал** | **Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, тайланг хагас, бүтэн жилээр БХБЯ-нд хүргүүлж, дүгнүүлсэн.** | **Журманд заасан хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тайлагнасан байна.** | | |
| 4.1.6.1 | Байгууллагын болон зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж, тайлагнах | Үйл ажиллагаа | 14 төлөвлөгөө, 28 тайлан | 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас, бүтэн жилийн тайланг БХБЯ-нд хүргүүлж дүгнүүлсэн. Зохион байгуулалтын 13 нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, улирал бүрийн 46 тайланг гарган дүгнэж, архивласан. | Байгууллагын болон Зохион байгуулалтын нэгжийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна.<br>Байгууллагын төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.<br>Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр гарган дүгнүүлсэн байна. | Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд тусгуулахаар 3 газар, 10 хэлтсээс ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн.<br>Монгол Улсын ерөнхий Сайдын 2024 оны 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 14 дүгээр захирамжаар батлагдсан "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц"-ийн дагуу "Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г шинэчлэн боловсруулж, 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Агентлагийн даргаар батлуулсан.<br>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан 3 газар, 10 хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах ажлыг 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан.<br>Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, хангалтгүй хэрэгжиж байгаа арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор нэгжийн дарга албан хаагчтай хийх явцын ярилцлагыг 2 удаа зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажилласан. | |
| 4.1.6.2 | 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-ны гүйцэтгэлийн | Үйл ажиллагаа | 22 төлөвлөгөө, 44 тайлан | 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас, бүтэн жилийн тайланг хүлээн | 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг | ГЗБГЗЗЕГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлтэй уялдуулан 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөг боловсруулах, батлах, хагас, бүтэн жилийн тайланг хүлээн авч, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх | | | авч, хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулсан. | боловсруулж, батлуулсан байна. Төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр хүлээн авч, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулсан байна. | ГЗБА-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, тус газрын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/170 дугаар албан бичгээр 21 аймгийн ГХБХБГ-аас, мөн өдрийн 1/171 дугаар албан бичгээр нийслэлийн ГЗБА-аас тус тус санал авч саналыг хянаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнүүдийг эцэслэн боловсруулж, 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр "Салбарын удирдах ажилтны зөвлөгөөн"-өөр батлуулах арга хэмжээг зохион байгуулсан.<br>21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-ны 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхээр тайлан ирүүлэх тухай 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 1/1455 дугаар албан бичгийг хүргүүлсэн. | |
| 4.1.6.3 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Нийт албан хаагчдын төлөвлөгөө, тайлан | 2023 онд албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг жилээр, гүйцэтгэлийн тайланг улирал бүр гарган үнэлгээ, дүгнэлт өгч ажилласан. | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах ажлыг зохион байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | Зохион байгуулалтын 3 газар, 10 хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн Агентлагийн даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн Б/26 дугаар тушаалаар батлагдсан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын албан тушаалын жагсаалтын дагуу Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулсан.<br>Тус агентлагийн 3 газар, 10 хэлтсийн төрийн захиргааны 76 албан хаагч, 14 төрийн үйлчилгээний албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгжийн даргаар батлуулах ажлыг зохион байгуулсан.<br>Албан хаагчид болон нэгжийн 2024 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, маш сайн үнэлэгдсэн 73, хэвийн | |



85

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнэлэгдсэн 8 албан хаагчдад улирлын ажлын үр дүнгээр урамшуулал олгосон.<br>Үнэлгээний мөрөөр албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөөний хангалтгүй байгаа арга хэмжээний биелэлтийг хангуулах, цаашид анхаарах асуудлаар зөвлөмж, чиглэл хүргүүлэх зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгууллагын 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлангийн хурлыг зохион байгуулсан. | |
| **4.1.7** | **Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдал тын хувь** | - | **Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.** | | |
| 4.1.7.1 | Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Урсгал зардал | 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА, 9 ДГЗБА | 2023 онд 8 аймгийн ГХБХБГ болон Нийслэлийг ГЗБА-ны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | **Жилийн эцэст:**<br>21 аймгийн ГХБХБГ, НГЗБА, 9 дүүргийн ГЗБА-ны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.<br>Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулсан байна. | Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөний төслийг батлуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | |
| **4.1.8** | **Хурал, зөвлөгөөн зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Зохион байгуулагдсан арга хэмжээ** | **2023 онд 5 хурал, 3 зөвлөгөөн зохион байгуулагдсан.** | **Хурал, зөвлөгөөн, форумыг хугацаанд нь зохион байгуулж, биелэлтийг тайлагнасан байна.** | | |
| 4.1.8.1 | Ерөнхий сайдаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, Газрын удирдах ажилтны шуурхай | Үйл ажиллагаа | Удирдах ажилтны шуурхай хуралдааны тоо, өгсөн үүрэг | 2023 онд БХБС-ын шуурхай хуралдаан 24 удаа зохион байгуулагдаж, 117 үүрэг даалгавар, "Удирдах ажилтны шуурхай хуралдаан" 24 удаа | Газрын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, хурлаас өгөгдсөн үүрэг, даалгаврыг "Байгууллагын удирдлагын цогц систем"-д оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнасан байна. | Тайлант хугацаанд 21 удаагийн удирдах ажилтны шуурхай хуралдааныг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 405 үүрэг даалгавар өгөгдсөн бөгөөд 77,2%-ийн хэрэгжилттэй ажилласан | |



86

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвлөгөөнийг зохион байгуулах, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих | | даалгаврын тоо | зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 459 үүрэг даалгавар өгөгдсөн. | | | |
| 4.1.8.2 | Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлыг зохион байгуулах, хурлаас өгсөн үүрэг даалгаврыг албажуулах, тайлагнах | Үйл ажиллагаа | Хуралдааны тоо, хэлэлцсэн асуудлын тоо | 2023 онд 12 хурлыг зохион байгуулж, 49 асуудал хэлэлцэж, шийдвэрлэсэн. | Газрын даргын 2024 оны даргын дэргэдэх зөвлөлийн хурлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, үүрэг даалгаврыг албажуулж, тайлагнасан байна. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2024 оны даргын дэргэдэх зөвлөлийн хурлын төлөвлөгөөний дагуу 2024 оны эхний хагас жилийн байдлаар тус хурлыг 12 удаа зарлан хуралдуулж, 53 асуудал хэлэлцэж, хурлаас гарсан шийдвэрийг албажуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Мөн Агентлагийн даргын 2024 оны А/195 дугаар тушаалаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлын дэг, бүрэлдэхүүнийг шинэчлэн боловсруулж батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| 4.1.8.4 | Салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 1 зөвлөгөөн | Удирдах ажилтны зөвлөгөөнийг 2023 онд 2 удаа зохион байгуулсан. | **Эхний хагас жилд:** Салбарын "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ий төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж, зөвлөгөөнийг зохион байгуулсан байна. | Салбарын "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ийг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулсан. | |
| 4.1.8.5 | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөгөө, арга хэмжээний тоо | 2023 оны 5 дугаар сарын 01-нд зохион байгуулагдсан. | Монгол Улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ой, Газрын харилцааны ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж, арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагаанд оролцсон байна. | Ерөнхий сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн 35 дугаар захирамжаар Газрын харилцааны мэргэжлийн байгууллага байгуулагдсаны 70 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулахыг тус Агентлагт үүрэг болгосон. Энэхүү шийдвэрийн хүрээнд Газрын харилцааны мэргэжлийн байгууллага байгуулагдсаны 70 жилийн ойн | |



87

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд хийгдэх 70 бүтээлч ажлын төлөвлөгөөг Агентлагийн даргын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар батлагдсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| 4.1.8.6 | Евроазийн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн 10 дугаар хуралдаан зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хурал зохион байгуулсан байдал | - | **Жилийн эцэст:**<br>Олон улсын хурлын зохион байгуулалтын үйл ажиллагаанд оролцсон байна. | Евроазийн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн 10 дугаар хуралдаан зохион байгуулах ажлын хэсгийг Агентлагийн даргын 2024 03 дугаар сарын 19-ний өдрийн А/87 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| **4.1.9** | **Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь** | **Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр батлагдсан.** | **Хөтөлбөрийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.** | | |
| 4.1.9.1 | Батлагдсан "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа/ Урсгал зардал | Сургалтын тоо | "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх 2022 сургалт, хөгжлийн төлөвлөгөөг 4 дэд хэсэгт 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, боловсруулж тус газрын даргын 2022 оны А/39 дүгээр тушаалаар баталж, хэрэгжилтийг хүргүүлсэн. | "Салбарын хэмжээнд байгууллагаас хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө"-г боловсруулан Газрын даргаар батлуулж, хэрэгжүүлж ажилласан байна.<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр БХБЯ-нд тайлагнасан байна. | 2024 оны сургалт, хөгжлийн төлөвлөгөөг 4 дэд хэсэгт 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, боловсруулж Агентлагийн даргын 2024 оны А/86 дугаар тушаалаар батлуулж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>2024 оны сургалт хөгжлийн төлөвлөгөөнд.<br>1. Уулзалт, зөвлөгөөн:<br>-Хэрэгжүүлэх арга хэмжээ-3<br>-Хэрэгжсэн-3<br>2.Аймгийн ГХБХБГ, Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагч, сумын газрын даамлуудад зориулсан сургалт:<br>-Хэрэгжүүлэх арга хэмжээ-19<br>-Хэрэгжсэн-8<br>-Хэрэгжих шатандаа болон хугацаа болоогүй- 11<br>3.Агентлагийн албан хаагчдад зориулсан сургалт: | |



83

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Төлөвлөсөн арга хэмжээ-11<br>-Хэрэгжсэн-5<br>-Хэрэгжих шатандаа болон хугацаа болоогүй-6<br>4.Салбарын мэргэжлийн байгууллагын захиалгаар зохион байгуулах сургалт:<br>-Төлөвлөсөн арга хэмжээ-7<br>-Хэрэгжсэн-3<br>-Хэрэгжих шатандаа болон хугацаа болоогүй-4<br>Дээрх төлөвлөгөөг ил тод, нээлттэй байдлаар байгууллагын вэб сайтад байршуулсан.<br>Газрын харилцааны салбарын албан хаагчдад зориулсан "2024 оны Сургалт, хөгжлийн төлөвлөгөө"-г аймгийн ГХБХБГ, нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | |
| **4.1.10** | **Гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь** | **2021 оны хамтын ажиллагааны төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн.** | **Төлөвлөгөөг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.** | | |
| 4.1.10.1 | Гадаад, дотоод хамтын ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө, 2 тайлан | Гадаад, дотоод хамтын ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Гадаад, дотоод хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | Гадаад, дотоод хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулж Агентлагийн даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/61 дүгээр тушаалаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | |
| 4.1.10.2 | Бусад орнуудын ижил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллагуудтай хамтын ажиллагаа эхлүүлэх, тогтмолжуулах | Үйл ажиллагаа | Хамтын ажиллагаа эхлүүлсэн байгууллагын тоо | - | Хамтын ажиллагаа тогтмолжсон байна. | Агентлагийн даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/61 дүгээр тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд:<br>- "Монголын-Гео мэдээллийн холбоо" ТББ-тай хамтын ажиллагаа эхлүүлэх санамж бичиг байгуулахаар санал авсан.<br>- ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнтэй хамтран ажиллах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэрээ байгуулахаар санал авч дуусан байна<br>- АНУ-ын Мэйдисон хотын Висконсины Их сургуультай хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар санал авсан.<br>- БНСУ-ын "LX" газрын корпорацтай хамтын ажиллагааны санамж бичиг боловсруулж байна.<br>- Япон улсын Гео-орон зайн мэдээллийн албатай хамтран ажиллах гэрээ байгуулахаар тус тус санал хүргүүлсэн.<br>- Найрамдах Хятад Ард Улсын байгалийн нөөцийн яамтай ZY-3 хиймэл дагуулын санамж бичиг сунгах бичиг боловсруулж байна.<br>- БНСУ-ын Дотоод хэрэг, аюулгүй байдлын яамны дэд сайд Ким Мин Жэ болон ГЗБГЗЗЕГ-ын дарга А.Энхманлай нар Монгол улсын хаягийн мэдээллийн системийг шинэчлэх, шинэ технологийг нэвтрүүлэх, боловсон хүчнийг сургаж, хөгжүүлэхэд хамтран ажиллаж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Санамж бичиг байгуулсан.<br>- Японы гео-орон зайн мэдээллийн газартай Монгол Улсын гравиметрийн нэгдүгээр ангийн сүлжээний гурван маркийн (Gr0001, Gr0033, Gr0017) цэгийн хүндийн хүчний хурдатгалын үнэмлэхүй утгыг тодорхойлж, хэмжилтийн өгөгдлийг боловсруулахаар санамж бичиг боловсруулж тус тус санал хүргүүлсэн.<br>- 2024.05.21-ны өдөр МОНГОЛЫН ИНТЕРНЭТ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН" ТББ-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - 2024.05.21-ны өдөр "МЭ МАРКЕТИНГ ЭНТЕРТАЙНМЕНТ" ХХК- тай төрөөс баримтлах бодлого, батлагдсан хууль тогтоомжуудыг иргэд олон нийтэд сурталчлах газрын цахим үйлчилгээг иргэдэд таниулах медиа контентыг хийхээр ажил гүйцэтгэх гэрээ тус тус байгуулсан. | |
| 4.1.10.3 | Байгууллагын удирдлагуудын олон улсын байгууллагын шугамаар оролцох хурал, уулзалт, эксло, сургалт зэрэг арга хэмжээнүүдийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг хангах, томилолтын үйл явцад дэмжлэг үзүүлэх | Үйл ажиллагаа | Арга хэмжээний тоо | - | Удирдлага, албан хаагчдын оролцох хурал, уулзалт, сургалт, хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээнүүдийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг хангаж, томилолтын үйл явцад дэмжлэг үзүүлсэн байна. | Байгууллагын 2024 оны Гадаад, дотоод хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээг зохион байгуулсан.<br>- 2024.03.26-2024.04.02-ны өдрүүдэд БНСУ-ын "LX" корпорацын төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулсан.<br>- 2024.03.25-30-ны өдрүүдэд Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах Геодези, байр зүйн ажлын хэсгийн хуралд 2 албан хаагч хурал, зөвлөгөөнд оролцсон.<br>- 2024.3.19-23-ны өдрүүдэд Монгол Улсын Хилийн боомтын захиргаа, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Боомтын захиргааны алба хоорондын хамтын ажиллагааны ажлын хэсгийн нэгдүгээр улирлын уулзалтад 1 албан хаагч оролцсон.<br>- 2024.04.22-26-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Филиппин Улсын Манила хотод зохион байгуулагдах "Навигацийн хиймэл дагуулын хэрэглээ" сэдэвт сургалтад 1 албан хаагч оролцсон.<br>- 2024.05.24-ний өдөр Монгол улсын хаягийн мэдээллийн системийг шинэчлэх, шинэ технологийг нэвтрүүлэх, боловсон хүчнийг сургаж, хөгжүүлэхэд хамтран ажиллаж, төсөл хөтөлбөр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлэх Санамж бичиг байгуулахаар 2 албан хаагч албан томилолтоор явсан.<br>- 2024.05.27-31-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хайкоу хотод зохион байгуулагдах "Зайнаас тандан судлалын мэдээлэл боловсруулах болон газрын суултын хяналт" сэдэвт сургалтад 1 албан хаагч тус тус оролцсон. | |
| **4.1.11** | **Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод, шуурхай байх нөхцөл боломжийг бүрдүүлэх** | **Үйл ажиллагаа** | - | - | **Байгууллагын үйл ажиллагааны мэдээ олон нийтэд шуурхай хүрдэг болсон байна.** | | |
| 4.1.11.1 | Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан арга хэмжээний тоо | Нийт 63 мэдээ, сурвалжлага, 30 постер, хуулийн төслийн хэлэлцүүлгүүдийг бие даасан мэдээлэл болгон боловсруулж, сошиал орчинд 14 сайтад түгээсэн. | Салбарын үйл ажиллагаатай холбоотой 25 ярилцлага зохион байгуулж, 50 мэдээ мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр сурталчилсан байна. | ГЗБГЗЗЕГ-ын веб хуудасны мэдээллийг тогтмол шинэчилсэн.<br>Салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг байгууллагын веб хуудас болон олон нийтийн цахим сүлжээгээр 28 удаа рийл, 11 видео контент, 12 удаа шууд дамжуулалт, 2 удаа телевизийн мэдээ сурвалжилга, 2 удаа сайт ярилцлага мэдээ, 48 ширхэг постер мэдээ, 104 пост мэдээ байршуулан сурталчлан ажилласан. | |
| 4.1.11.2 | Цахимд суурилсан газрын нэгдсэн лавлах 1900-0101 тусгай дугаараар иргэдэд үйлчлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Дуудлагын тоо | 2023 онд 1900-0101 тусгай дугаарт холбогдсон 12598 иргэн зааварчилгаа авч, цахимаар үйлчилгээ авсан. | 1900-0101 тусгай дугаараар авах дуудлагын тоог 5 хувиар нэмэгдүүлж, цахимаар үйлчилгээ авах иргэдийн тоог нэмэгдүүлж ажилласан байна. | 2024 оны эхний хагас жилийн байдлаар 1900-0101 тусгай дугаарт нийт 9243 дуудлагад хариулт өгч ажиллалаа.<br>- Нийт дуудлагад 92%-тай хариулсан.<br>- Байгууллагын төсөвт 2024 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн байдлаар 9,297,000 (есөн сая хоёр зуун ерэн долоон мянган) төгрөгийн орлого төвлөрүүлсэн.<br>- Олон нийтийн сошиал хаягийн дагагчийн тоо 60262 иргэн болж 4500 хүн шинээр нэмэгдсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.11.3 | Цахимд суурилсан газрын нэгдсэн лавлахын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | Үйл ажиллагаа | Авсан арга хэмжээний тоо | - | Egazar.gov.mn системтэй холбоотой асуудлаар иргэдээс ирсэн санал гомдлыг нэгтгэж, шинэчлэл хийх талаар санал боловсруулж, удирдлагад танилцуулсан байна. Мэдээллийн ажилтнуудыг сургалтад хамруулсан байна. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын албан ёсны пейж хуудаст ирсэн 2434 иргэний асуултад чатботаар хариу илгээж, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны албан ёсны пейж хуудаст 7200 иргэнд, нийтдээ 9634 иргэнд цахимаар хариу илгээж ажиллаа. | |
| 4.1.11.4 | Байгууллагын албан ёсны цахим хаягуудаар контент (подкаст) бэлтгэн хүргэх | Үйл ажиллагаа | Бэлтгэсэн контентын тоо | | Контентийг бэлтгэсэн байна. | Байгууллагын албан ёсны цахим хуудсаар газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн газар эзэмших эрхийн цахим хүсэлтийг багц үйлчилгээг бүрээр 17 удаагийн рийл видео контент бэлтгэн олон нийтэд хүргэсэн.<br>Шинээр нэвтрүүлж буй үйлчилгээг олон нийтэд хүргэх зорилгоор 2 үйлчилгээний 8 хавтгай эх бэлтгэлийг бэлтгэн нийтлэхээр бэлэн болгоод байна. Үүнд: Шилэн газар үйлчилгээ, Шинээр газар эзэмших эрхийн цахим хүсэлтийн заавар, "Хариуцлагатай газрын харилцаа" аяны хүрээнд 11 удаагийн рийл, 3 удаагийн видео контент, 38 ширхэг хавтгай эх бэлтгэл, 4 шууд дамжуулалтын контентыг бэлтгэн хүргэсэн байна. | |
| 4.1.11.5 | Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах 1111" төвөөс ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих | Үйл ажиллагаа | Авсан арга хэмжээний тоо | | "Иргэд, олон нийттэй харилцах 1111" төвөөс ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авч, холбогдох нэгжүүдээр шийдвэрлүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажилласан байна. | Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах 1111" төвөөс ирүүлсэн 50 иргэний өргөдөл, гомдол, санал хүсэлтийг холбогдох хэлтэс, албан хаагчдад шилжүүлэн хугацаанд нь шийдвэрлүүлж ажилласан. Шийдвэрлэлт 70 хувийн үзүүлэлттэй байна. | |
| 4.1.11.6 | Газрын ерөнхий хууль, багц хуулиудын төслүүдийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, | Үйл ажиллагаа | Нийт хэлэлцүүлгийн тоо | | Иргэд, олон нийтэд сурталчлан таниулсан байна. | Дархан-Уул аймагт 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан "Иргэдийн индэр" нээлттэй хаалганы өдөрлөгийг Дархан-Уул аймгаас шууд дамжуулан хүргэж, газрын багц хуультай холбоотой асуултад хариулт өгч, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлэлцүүлгүүд зохион байгуулах | | | | | хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтэд танилцуулсан. "Хариуцлагатай газрын харилцаа" аяны хүрээнд хууль сурталчлан таниулах зорилгоор "Анар и эл эс" ХХК-тай гэрээ байгуулан 50 постер, 32 рийл, 5 брошюрыг бэлтгэн төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар нийтлэн ажиллаж байна. | |
| **4.1.12** | **Албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагааны зардал** | **Баримт бичиг** | **2023 онд 4000 албан бичиг, 600 өргөдөл, гомдол хүлээн авсан.** | **Газарт ирсэн, явсан, өргөдөл гомдолыг "Байгууллагын удирдлагын цогц цахим систем"-д бүртгэлжүүлж, тайлан мэдээг гаргасан байна.** | | |
| 4.1.12.1 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэж, тайлагнах | Үйл ажиллагаа | Ирүүлсэн албан бичгийн тоо-3600<br><br>Явуулсан албан бичгийн тоо-2500<br><br>Өргөдөл-500<br><br>Тайлан-28 | 2023 онд 4000 албан бичиг, 600 өргөдөл, гомдол хүлээн авсан.<br>2800 албан бичигт дугаар өгсөн байна. | Байгууллагад ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэж, холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байна.<br>Байгууллагаас явуулж буй албан бичгийг бүртгэж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.<br>Хариутай албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ тайланг тухай бүр гаргаж, тайлагнасан байна.<br>Өргөдөл, гомдлын тайлан, мэдээг улирал бүр гарган, БХБЯ-нд хүргүүлсэн байна. | Төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн албан бичгийн бүрдлийг шалгаж, албан хэрэг хөтлөлтийн программ хангамж ашиглан бүртгэж, холбогдох газар, хэлтэст хугацаанд нь шилжүүлэн ажиллаж байна.<br>2024 оны эхний хагас жилийн байдлаар тус Агентлагт нийт 1821 албан бичиг ирсэн.<br>Нийт албан бичгийн 967 хариугүй албан бичиг, 854 хариутай албан бичиг ирсэн байна. Хариутай албан бичгийн 796 албан бичиг хугацаандаа шийдвэрлэсэн, хугацаа хоцорч шийдвэрлэсэн 50 албан бичиг, 56 албан бичиг хяналтад байгаа, хугацаа хэтэрсэн 2 албан бичиг байна.<br>Байгууллагаас төрийн болон төрийн бус байгууллага руу нийт 2592 албан бичиг явуулсан.<br>2024 оны 2 дугаар улирлын байдлаар байгууллагад нийт 386 өргөдөл, гомдол ирүүлсний 365 өргөдөл, гомдол хариутай байна үүнээс шийдвэрлэсэн 147, хяналтад байгаа 44, хугацаа хоцорч шийдвэрлэсэн 3 өргөдөл, гомдол, шийдвэрлээгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаа хэтэрсэн 19 өргөдөл, гомдол байна<br>Хэвлэмэл хуудас:<br>Тушаалын хэвлэмэл хуудас 727, А4 албан бичгийн хэвлэмэл хуудас 2501, А5 албан бичгийн хэвлэмэл хуудас 1852-ыг зарцуулсан байна. | |
| 4.1.12.2 | Байгууллагын удирдлагын ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | Үйл ажиллагаа | Дэмжлэг үзүүлсэн тоо | - | Газрын удирдлагын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, уулзалт, хурлыг цаг хугацаанд нь зохион байгуулсан байна. | Агентлагийн удирдлагын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, уулзалт хурлыг цаг тухайд нь зохион байгуулж, газрын даргаас албан хаагчдад өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт дээр анхаарч, арга хэмжээний бүртгэлийг хөтлөн, цагийг зохицуулж ажилласан болно. 2024 онд:<br>- 106 албан хаагчдад шинээр ажлын үнэмлэх олгосон.<br>- Гадаад болон Дотоод томилолтоор ажилласан 48 4-5-6 сар 18 албан хаагчдад "Томилолтын хуудас" олгож, бүртгэл хөтөлж, тус газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/188 дугаар тушаалаар батлагдсан "Албан хаагчдыг албан томилолтоор ажиллуулах журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хяналт тавьж ажилласан.<br>- Мөн байгууллагын 205 тоот хурлын танхимд нийт 84 удаагийн уулзалт, хуралдаан, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. | |
| **4.1.13** | **Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **Хадгаламжийн нэгж** | **Байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 онд 358 хадгаламжийн нэгж үүсгэсэн.** | **Байгууллагын архивт баримт хүлээн авах, бүртгэх, нягтлан шалгалт хийх, тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах, хадгалах, хамгаалах, ашиглуулах, данс бүртгэл хөтлөх, устгах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулсан байна.** | | |



95

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.13.1 | Байгууллагын архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах | Үйл ажиллагаа | 1 жагсаалт, 1 хуваарь, 300 хадгаламжийн нэгж | 2023 онд Байгууллагын хөтөлж дууссан баримтыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 358 хадгаламжийн нэгж үүсгэн архивласан. | **Эхний хагас жилд:**<br>2024 оны байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, нөхөн бүрдүүлэх хуваарь гарган батлуулсан байна.<br>2023 оны "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт" болон нөхөн бүрдүүлэх хуваарийн дагуу хөтөлж дууссан баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивласан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Хөтөлж дууссан баримтад сан хөмрөг үүсгэх, архивлах, үдэж хавтаслах техник боловсруулалт хийх, гадна бичилт хийх зэрэг ажлуудыг архивын жилийн ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн байна.<br>2024 оны "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон тендер шалгаруулалтын баримтыг архивласан байна. | Байгууллагын 2023 оны "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ын дагуу архивыг нөхөн бүрдүүлэх хуваарийн дагуу албан хэрэг хөтлөлтийн явцад хөтөлж дууссан 302 хадгаламжийн нэгжийн бүрдлийг хангуулан нягтлан шалгаж, архивласан. Үүнд:<br>- 2023-2024 оны "Худалдан авах ажиллагаа"-ны тендер шалгаруулалтын 19 хадгаламжийн нэгж;<br>- Албан хэрэг хөтлөлтийн явцад хөтөлж дууссан 183 хадгаламжийн нэгж;<br>- 2023 оны 46 хадгаламжийн нэгж;.<br>- Агентлагийн даргын 2023-2024 оны А/01-А/204, А/01-А/194 тушаал, хүний нөөцийн холбогдолтой 2023-2024 оны 250 тушаал;<br>2023-2024 оны байгууллагын удирдлагын баталсан "Ажлын даалгавар, гэрээ, тусгай зөвшөөрлийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөө , нэгжийн болон албан хаагчийн улирлын тайлангийн цаасан болон цахим баримтаар архивын нэгж үүсгэн баяжуулсан.<br>/Tushaal //192.168.20.6 дотор W:\2003-2024_tushaal-д хэсэгчлэн оруулж, цахимжуулж архивласан.<br>Агентлагийн даргын 2024 оны А/174 дүгээр тушаалаар "Байгууллагын архивын үйл ажиллагааны журам", А/175 дугаар тушаалаар Байгууллагын баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн, дүрмийг тус тус батлуулсан. | |
| 4.1.13.2 | Архивын баримтаар байгууллага, иргэдэд үйлчилгээ үзүүлэх, лавлагаа мэдээлэл олгох, | Үйл ажиллагаа | -Архивын баримт ашиглах, хуулбар, лавлагаа | Нийт архивын үйлчилгээний хөлсийг /54000 төгрөг/ тооцуулсан. Байгууллагын архивын | Лавлагаа, хүсэлтийн тоогоор архивын баримт ашиглуулах, хуулбар олгох, байгууллагын хэрэгцээнд архивын цаасан болон цахим баримт | 2024 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын архивын баримтаар байгууллага, иргэд, албан хаагчдад дараах үйлчилгээг үзүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | "Хүн, хуулийн этгээдэд архивын баримт ашиглуулах журам"-ыг хэрэгжүүлэх | | авах хүсэлтийн тоо<br>- Байгууллагын хэрэгцээнд ашиглуулсан архивын цаасан болон цахим баримтын тоо | 1451 хуудас цаасан болон цахим баримтаар үйлчилгээ үзүүлсэн. | ашиглуулах үйлчилгээ үзүүлсэн байна. | - Байгууллагад ирүүлсэн 11 албан бичиг, 22 иргэний бичгээр ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг хүлээн авсан;<br>- Тэтгэвэр тогтоолгохтой холбоотой ажилласан жилийн лавлагаа, нийгмийн даатгалын байгууллагуудаас шаардсан цалингийн баримтыг шуурхай шийдвэрлэж хүргүүлсэн.<br>- Нийт 441 хадгаламжийн нэгжид давхардсан тоогоор баримт шүүж, 24/01-24/209 дугаараар 1124 хуудас баримтыг баталгаажуулан "Хуулбар үнэн" бичилт хийж үйлчилгээ үзүүлсэн.<br>- Байгууллагын хэрэгцээнд 643 хуудас цахим болон цаасан баримтыг хуулбарлан ашиглуулсан.<br>- Байгууллага дээр ажилласан Үндэсний аудитын хяналт шалгалтад удирдлагын болон санхүүгийн 38 хадгаламжийн нэгжийг ашиглуулсан Хугацаа хоцорч шийдвэрлэсэн албан бичиг байхгүй болно.<br>https://www.gazar.gov.mn/p/p-999-105 | |
| 4.1.13.3 | Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын дотоод зохион байгуулалтын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, байгууллагын архивын чиг үүргийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | - | **Эхний хагас жилд:**<br>Архивын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гаргаж, Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангасан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулж. төлөвлөгөөг хэрэгжүүлж, дүгнүүлсэн байна. | Архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэгт бэлтгэх, зохион байгуулах байгууллагын ажлын хэсгийг Агентлагийн даргын 2023 оны А/39 дүгээр тушаалаар батлуулсан.<br>Архивын хадгаламжийн санд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шинээр худалдан авах жагсаалт гарган төсөвлөж нэгжийн даргаар хянуулан 2-р сард СЭЗХ-ийн даргад хүргүүлэн, Салбарын архивын хэлтсийн "Худалдан авах ажиллагаа"-нд нэгтгэн оруулсан.<br>Байгууллагын архивыг нөхөн бүрдүүлэх хуваарь, 2024 оны "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний дагуу боловсруулан санал авахаар төлөвлөсөн.<br>Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын дотоод зохион байгуулалтын Улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө боловсруулан Салбарын архивын хэлтэстэй хамтран хэлтэс тус бүрээс санал авч нэгтгэн батлуулсан. | |

## ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | Үйл ажиллагаа | Үүрэг даалгаврын тоо | Жил бүр хийгддэг. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна. | Газрын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 21 удаа зохион байгуулагдаж өгөгдсөн үүрэг даалгаврыг байгууллагын удирдлагын цогц, онлайн системд байршуулж тухай бүр хэрэгжүүлж ажилласан. | |
| 4.1.2 | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Тушаалд заасан хугацаа | Жил бүр хийгддэг. | Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна. | Агентлагийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/175 дугаар тушаалаар батлагдсан ГЗБГЗЗЕГ-ын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж 2024 оны 01 дүгээр сард нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлж, батлагдсан.<br>Агентлагийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Б/07 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн Нарийн бичгийн даргаар ажиллаж Нийслэл, аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт"-ыг шинэчлэн боловсруулж мөн албан | |



98

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанд танилцуулсан.<br>Агентлагийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар батлагдсан аймаг, нийслэлийн Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг хүлээн авч, нэгтгэн, нэгдсэн тайланг гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж мэдээ, судалгааг нэгтгэн танилцуулсан.<br>Агентлагийн даргын 2024 оны А/110 дугаар тушаалаар байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт тус газрын 7 албан хаагч оролцож, тус нэгжээс боловсруулсан 6 баримт бичгийг шинэчлэн боловсруулж батлуулсан бөгөөд 5 журмыг даргын тушаалаар батлуулахад бэлэн болсон байна. | |
| 4.1.3 | Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | Жил бүр хийгддэг. | Холбогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна. | - БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Б/06 дугаар тушаал;<br>- Төрийн албаны зөвлөлийн БХБЯ-ны дэргэдэх салбар зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоол;<br>- ЗГ-ын 2023 оны 301 дүгээр тогтоол;<br>- ЗГ-ын 2020 оны 217 дугаар тогтоол;<br>- ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаал;<br>- ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаал;<br>- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоол;<br>- Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоол;<br>- Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоол;<br>- Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын хэрэгжилтийг тус тус хангаж ажиллаж байна. | |
| 4.1.4 | Хугацаатай албан бичиг, өргөдөл | Үйл ажиллагаа | Шийдвэрлэсэн албан | Жил бүр хийгддэг. | Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан | Төрийн захиргаа, удирдлагын газрын хэмжээнд 2024 оны эхний хагас жилийн | |



99

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | | бичиг, өргөдөл, гомдлын тоо | | хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | байдлаар нийт 165 бичиг ирснээс хариугүй бичиг 122, хариутай бичиг 43, үүнээс шийдвэрлэсэн бичиг 42, шийдвэрлэлтийн шатанд 1, хугацаа хоцорч шийдвэрлэсэн 2 албан бичиг байна.<br>Мөн иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдол нийт 85 ирснээс хариутай өргөдөл, гомдол 84, хариугүй өргөдөл, гомдол 1, үүнээс шийдвэрлэсэн өргөдөл, гомдол 76, шийдвэрлэлтийн шатанд 9, хугацаа хоцорч шийдвэрлэсэн 5 өргөдөл, гомдол байна. | |
| 4.1.5 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Үйл ажиллагаа | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | Жил бүр хийгддэг. | Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | 2023 оны "Б" тушаалуудыг архивын хадгаламжийн нэгж болгон хүлээлгэн өгсөн.<br>Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архив нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг хүлээлгэн өгсөн. | |

__oOo__

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ ДАРГА Б.ЭНХБОЛД



100